



# ART IN EMBASSIES EXHIBITION

United States Embassy Ulaanbaatar, Mongolia

**SZCZEKOT Sunny and Sopris, September 23, 2013**

*Color photograph, 24 x 36 in. Courtesy of the artist, Carbondale, Colorado*

**ЗЕШИКОТ Нарлаг өдөр, Соприс уул, 2013 оны 9-р сарын 23**

*Өнгөт гэрэл зураг, 61 x 91,4 см. Уран бүтээлчийн зөвшөөрөлтэй. Колорадо муж, Карбондэйл хот*

# ART IN EMBASSIES



Established in 1963, the U.S. Department of State's office of Art in Embassies (AIE) plays a vital role in our nation's public diplomacy through a culturally expansive mission, creating temporary and permanent exhibitions, artist programming, and publications. The Museum of Modern Art first envisioned this global visual arts program a decade earlier. In the early 1960s, President John F. Kennedy formalized it, naming the program's first director. Now with over 200 venues, AIE curates temporary and permanent exhibitions for the representational spaces of all U.S. chanceries, consulates, and embassy residences worldwide, selecting and commissioning contemporary art from the U.S. and the host countries. These exhibitions provide international audiences with a sense of the quality, scope, and diversity of both countries' art and culture, establishing AIE's presence in more countries than any other U.S. foundation or arts organization.

AIE's exhibitions allow foreign citizens, many of whom might never travel to the United States, to personally experience the depth and breadth of our artistic heritage and values, making what has been called a: "footprint that can be left where people have no opportunity to see American art."

<http://art.state.gov>

## ЭЛЧИН САЙДЫН ЯАМД ДАХЬ УРАН ЗУРАГ



АНУ-ын Төрийн Департаментын “Элчин сайдын яамд дахь уран зураг” хөтөлбөр нь 1963 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд түр хугацааны болон байнгын үзэсгэлэн, уран бүтээлчдийг оролцуулсан төсөл хөтөлбөрүүд, хэвлэмэл материал зэрэг соёл урлагийн өргөн хэмжээний үйл ажиллагаагаар дамжуулан манай улсын олон нийтийн дипломат ажилд чухал үүрэг гүйцэтгэдэг билээ. Түүнээс арваад жилийн өмнө Модерн урлагийн музей иймэрхүү дэлхийн хэмжээний дүрслэх урлагийн хөтөлбөрийг төсөөлөн харж байжээ. Ерөнхийлөгч Жон Ф. Кеннеди 1960-аад оны эхээр хөтөлбөрийн анхны захирлыг томилж, албан ёсоор эхлүүлжээ. Одоогийн байдлаар тус хөтөлбөр нь дэлхий даяар 200 гаруй оронд суугаа элчин сайдын яамд, консулын газар, элчин сайдын өргөөний олон нийтэд нээлттэй хэсгүүдэд АНУ-ын болон оршин суугаа улс орныхоо контемпорари урлагийн бүтээлүүдээс сонгон шалгаруулж, түр хугацааны болон байнгын үзэсгэлэнг зохион байгуулдаг байна. Эдгээр үзэсгэлэн нь хоёр улсын урлаг соёлын онцлог чанар, цар хүрээ болон олон талт байдлыг үзэгчдэд хүргэхийн зэрэгцээ уг хөтөлбөр АНУ-ын бусад ямар ч сан, урлагийн байгууллагаас илүүтэйгээр олон улс оронд хүрч ажиллаж байна.

Хөтөлбөрөөс гаргадаг үзэсгэлэнгүүд нь АНУ-д зочилж үзээгүй гадаадын иргэдэд манай урлаг соёлын өв, үнэт зүйлсийг бодитоор үзэж мэдрэх боломжийг олгодог болохоор “Америкийн урлагийг үзэх боломжгүй газар нутагт үлдэх зам мөр” хэмээн нэрлэгддэг юм.

<http://art.state.gov>

# INTO THE WILD

Welcome to the official Residence of the United States Ambassador to Mongolia. One of the great privileges of serving as Ambassador is the opportunity to showcase beautiful artwork by some of the finest artists of our time. I would like to thank the Art in Embassies program for their assistance in curating this exhibition, *Into the Wild*. It is noteworthy that all twelve works in this collection are on temporary loan to Art in Embassies for the purpose of this exhibit in my residence and office during my tenure as Ambassador. I would like to extend my sincere gratitude to the nine artists whose works you see displayed before you for their generous contributions toward enhancing cultural and artistic understanding between the United States and Mongolia.

For this exhibition, I have chosen pieces of art that I hope visitors will find both visually stimulating and inspiring. I am proud to feature artworks from both the United States and Mongolia around the theme of 'Into the Wild', which reflects the energy and vitality of the pieces in the exhibition – from the natural splendor of mountain landscapes in my home state of Colorado captured by photographers Shannon Szczekot and Tom Korologos, to the dynamism of Khasaanoviin Erdene-Ochir's *Wallop*. The bright colors of Francie Hester's timepieces, Carol Ann Waugh's *Undulations*, and Charlotte Ziebarth's *Urban Reflections* balance the softer images of Peggy Judy's *The Girls* and Jacob Brown's *Providence 3*. For those who have an opportunity to visit me in my office, I am proud to have on display a felt work by Colorado-based artist PJ Bergin, *Two Plus Seven*.

As I gaze at these images, I am drawn, as I hope you are, 'Into the Wild' — to run with wild horses on the plains of Colorado or the Mongolian steppe or to seek refuge in the cool, blue water of Lake Khuvsgul in northern Mongolia. I hope you enjoy these works of art and that they will help extend the bridge of mutual understanding and friendship between the United States and Mongolia.

**Jennifer Zimdahl Galt**

United States Ambassador to Mongolia

*Ulaanbaatar,  
November 2016*

# ОНГОН БАЙГАЛЬД

Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын албан ёсны өргөөнд тавтай морилно уу. Элчин сайдаар ажиллахын нэг давуу тал нь цаг үеийнхээ зарим шилдэг уран бүтээлчдийн сор бүтээлүүдийг олон нийтэд танилцуулах боломжтой байдагт оршдог. “Онгон байгальд” хэмээх энэхүү үзэсгэлэнг зохион байгуулахад гүн туслалцаа үзүүлсэн “Элчин сайдын яамд дахь уран зураг” хөтөлбөрт талархал илэрхийлж байна. Энэ цуглуулгад багтсан 12 бүтээлийг Элчин сайдаар ажиллах хугацаанд миний өргөө болон албан тасалгаанд байрлуулахаар энэхүү хөтөлбөрт түр хугацаагаар зээлдүүлснийг энд онцлон тэмдэглэмээр байна. Таны өмнө дэлгэсэн эдгээр бүтээлийг туурвисан 9 уран бүтээлчийн зүгээс Америкийн Нэгдсэн Улс болон Монгол Улсын хооронд соёл, урлагийн харилцааг улам нэмэгдүүлэхэд оруулж буй томоохон хувь нэмрийг нь үнэлж, тэдэнд чин сэтгэлийн талархал дэвшүүлж байна.

Өргөөнд минь зочлон ирэгсдийн сэтгэлийг сэргээж, мэлмийг баясгах бүтээлүүдийг энэхүү үзэсгэлэндээ зориулан сонгож чадсан хэмээн би найдаж байна. Гэрэл зурагчин Шэннон Сзекот, Том Корологос нарын хальснаа буусан миний төрөлх муж Колорадогийн уулсын сүр жавхаа, Хасаановын Эрдэнэ-Очирын “Төвөргөөн”-ий динамик хөдөлгөөн зэрэг энд тавигдсан бүтээлүүдийн эрч хүч, амьд эрчмийг илэрхийлсэн “Онгон байгальд” хэмээх сэдвийн хүрээнд америк, монгол уран бүтээлчдийн бүтээлүүдийг толилуульж байгаадаа бахархалтай байна. Фрэнси Хэстэрийн цаг хугацааны тухай хурц тод өнгийн зураглалууд, Кэрл Энн Вахын “Долгионууд”, Шэрлотт Зиебартийн “Хотын тусгалууд”-ыг Пегги Жюдийн “Охид” болон Жэйкоб Брауны “Провиденс 3” – ын зөөлөн зураглалууд тэнцвэржүүлж байна. Миний албан тасалгаанд зочлох хүмүүст Колорадогийн уран бүтээлч ПиЖэй Бергиний “Хоёр дээр нэмэх нь долоо” эсгий урлалын бүтээлийг дэлгэн үзүүлэхдээ таатай байх болно.

Энэ зургуудыг анхааралтай ажиглан харах тусам миний бие онгон дагшин байгальд уусан, Колорадогийн тэгш өндөрлөг, Монголын уудам талаар морин дэл дээр хийсгэх мэт, эсвэл Хөвсгөл далайн цэнгэг усанд сэрүүцэх мэт болдог. Та бүхэн ч үүнийг мэдрэх байх. Энд тавигдсан уран бүтээлүүд танд сэтгэлийн цэнгэл эдлүүлээд зогсохгүй Америкийн Нэгдсэн Улс болон Монгол Улсын харилцан ойлголцол, найрамдалт харилцааг улам өргөжүүлэхэд хувь нэмрээ оруулна гэдэгт итгэж байна.

**Женифер Зимдал Галт**

Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд

*Улаанбаатар хот  
Арваннэгдүгээр сар 2016*

## PJ BERGIN

“My primary body of work today is making felt from wool roving, hand-dyeing it and using this felt for commissioned wall art and sculpture. Felt making is both tactile and visual. With it I design and create original abstract wall art. Each piece is carefully embellished, making it truly one of a kind. The ‘drape’ of the tapestry when hung on a wall, lends maximum advantage to light and shadow, playing off my surface design.

Fabric, fiber, and thread have always been a constant in my career. In the beginning, I focused on advanced sewing techniques and apparel design – I made all of my own clothes, even in junior high school. At FIT [Fashion Institute of Technology, New York City], I learned about fabric and couturier pattern design, dyeing, and many other techniques. And in the last few years I have come full circle, back to my roots.”

PJ Bergin is an American felt and fiber artist and graduate of the Fashion Institute of Technology in New York City with majors in both apparel design and textiles. An avid felt maker, sewer, and knitter, she designs and produces site-specific Network Tapestry™ and other three-dimensional contemporary and abstract fiber art objects.

Bergin received her formal introduction to felting during a 1998 workshop led by the renowned felt maker, Chad Alice Hagen, at the Split Rock Campus in Duluth, Minnesota. There she learned the basics and theories behind making felt and how to build three-dimensional pieces using resists. Inlays, creating surface designs on solid colors, were also explored. In 2005, she began selling small-scale felted works of her own design.

In 2007, Bergin traveled to Pittsburgh, Pennsylvania, and the Society for Contemporary Craft, where, with Lisa Klakulak, she learned about the properties of wool and how to manipulate it to achieve different results from felting. During the workshop, she created freeform three-dimensional elements onto a base felt using resist techniques. Following that experience, Lisa Klakulak came to Bergin’s Felt In Hand studio and worked privately with her, providing advanced techniques in shaping felt and making inlays from pre-felted pieces.

<http://feltinhand.com>

## ПИЖЭЙ БЕРГИН

«Одоогоор миний голлон ажиллаж буй төрөл бол ноосоор эсгий хийж, гар аргаар будаад, түүнийгээ захиалгаар хийдэг ханын чимэглэл болон уран баримлын бүтээлдээ ашиглах явдал юм. Эсгий хийхэд хүрэлцэхүй болон харааны мэдрэмж аль аль нь хэрэгтэй. Эсгийгээр би өөрийн гэсэн өнгө аястай, ханын абстракт чимэглэл зохион бүтээдэг. Бүтээл болгонд маань нарийн чимхлүүр ажиллагаа ордог учраас онцгой болж чаддаг. Энэхүү эсгий чимэглэлийг хананд өлгөхөд гэрэл, сүүдрийн эффект дээд зэргээр нөлөөлж, гадаргуу дээрх загварыг улам тодотгож өгдөг юм.

Би амьдралынхаа туршид даавуу, мяндас, утсаар бүтээлүүдээ хийсээр ирсэн. Анхандаа би оёдлын дэвшилтэт технологи болон хувцас загварыг илүү сонирхож, бүр дунд сургуульд байхдаа бүх хувцсаа зохиогоод хийчихдэг байлаа. Дараа нь Нью-Йорк хотын ЗТДС /Загварын технологийн дээд сургууль/-д бөс даавуу болон дээд зэрэглэлийн хувцасны загвар гаргах, өнгө оруулах болон бусад олон арга техникүүдээс суралцаж билээ. Сүүлийн хэдэн жилд би үнэхээр өөрийн хүсч мөрөөдсөөр ирсэн зүйлээ хийж байна.”

ПиЖэй Бергин бол Америкийн эсгий болон даавуун урлалын уран бүтээлч бөгөөд Нью-Йорк хотын Загварын технологийн дээд сургуулийг хувцасны загвар, нэхмэл даавуугаар мэргэшиж төгсжээ. Тэрээр эсгий урлаач, оёдолчин, нэхмэлчин хүний хувьд Network Tapestry™ барааны тэмдэгтэйгээр тусгайлан урласан, мөн бусад гурван хэмжээст контемпорари болон абстракт бөс даавуун бүтээлүүдийн загварыг зохион бүтээдэг байна.

Бергин 1998 онд Миннесота мужийн Дулут хотын Сплит Рок оюутны хотхонд алдарт эсгий урлаач Чад Алис Хагены удирдсан семинарын үеэр эсгий урлалтай албан ёсоор танилцсан байдаг. Тэрээр эсгий хийх энгийн арга техникээс эхлээд онол, мөн хэв ашиглан 3 хэмжээст деталиудыг хэрхэн босгох талаар суралцжээ. Мөн эсгийнд хээ, зураг оруулан, цулгуй өнгөн дээр загвар гаргахад суралцсан байна. 2005 оноос эхлэн эсгий урлалын бүтээлүүдээ бага хэмжээгээр худалдаалж эхэлсэн байна.

2007 онд тэрээр Пенсильвани мужийн Питсбург хот дахь “Контемпорари урлагийн нийгэмлэг”-ээр зочлохдоо Лиза Клакулакаас ноосны шинж чанарууд, мөн хүссэн үр дүндээ хүрэхийн тулд эсгийгээр хэрхэн “тоглож” болох талаар суралцсан байна. Семинарын үеэр хэвэнд барьцалдуулах аргыг ашиглан эсгий суурь дээр чөлөөт хэлбэр бүхий 3 хэмжээст элементийг босгож сурчээ. Энэ туршилтын дараагаар Бергиний эсгий урлалын студид Лиза Клакулак хүрэлцэн ирж, түүнтэй хамтран ажиллаж эхэлсэн бөгөөд эсгийг хэлбэрт оруулах, эсгийгээр шигтгэмэл зураг хийх дэвшилтэт арга технологийг зааж сургасан байна.

<http://feltinhand.com>



**Two Plus Seven, 2010**

*Studio dyed, felt wool with metallic and painted accents, 38 x 62 in. overall. Courtesy of the artist, Salida, California*

**Хоёр дээр нэмэх нь долоо, 2010**

*Студид будсан, металл болон тод өнгийн деталь бүхий эсгий бүтээл, 96,5 x 157,5 см. Уран бүтээлчийн зөвшөөрөлтэй. Калифорни муж, Салида хот*

## JACOB BROWN

“I sustain myself through the creation of art. It is the creative act that gives me purpose. Having spastic cerebral palsy sets many limitations on my mobility and fine motor skills. These limitations form my visual language and my artistic process.

Looking back I can't remember a time when I wasn't involved in making art. Being the youngest in a creative family, I was always surrounded by the production of art and other projects. To create my art I use found materials from my father's garage and my brother's art studio.

My art is a reflection of the physicality of my movement and of the salvaged and found materials from my father's workshop and my brother's studio. It is through creating art that I give purpose to found materials and to myself. Art sustains me.”

Jacob Brown grew up in Mars, Pennsylvania. The youngest of three children, Brown recalls that making and creating art was an activity that his entire family participated in. Though his spastic cerebral palsy sets many limitations on his mobility and fine motor skills, it also forms his visual language and artistic process.

Brown's artwork has been featured in local, regional, and national exhibitions and has garnered several awards. His paintings are abstract creations that pulse with an amalgam of media, including pastels, inks, acrylics, oils, stains, lacquers, metal scraps, and metal leaf. The freedom of color and material on Brown's paintings are in contrast to his limited mobility due to spastic cerebral palsy.

Brown never lets his physical limitations get in the way of his creativity or his sense of adventure. An Eagle Scout and an avid adaptive skier, he rows competitively with the Three Rivers Rowing Association adaptive team. He also attends the St. Anthony Post-Secondary Program at Duquesne University in Pittsburgh, Pennsylvania, where he is an active member of Duquesne's Best Buddies chapter.

## ЖЭЙКОБ БРАУН

«Би уран бүтээлээрээ амьдардаг. Урлаж бүтээх нь надад зорилго бий болгодог. Тархины саажилттай болохоор хөдөлгөөний чадвар маань нилээд хязгаарлагдмал байдаг. Гэхдээ ийм хязгаарлагдмал байдал маань харааны хэл төдийгүй бүтээлч сэтгэлгээг хөгжүүлдэг юм.

Эргээд харахад уран бүтээл хийх ажилд оролцоогүй тийм үе байсан эсэхийг би санадаггүй юм. Уран бүтээлч гэр бүлийн отгон хүүхэд учраас бүтээл туурвил болон бусад төслүүд намайг үргэлж хүрээлж байв. Аавын гараж, ахын урлангаас олдсон янз бүрийн материалуудыг ашиглан уран бүтээлээ хийдэг.

Миний уран бүтээл бол миний хөдөлгөөний төдийгүй аавын урлан, ахын студид хаягдсан, тэндээс олдсон материалуудын тусгал юм. Би уран бүтээл хийх замаар өөрийгөө зорилготой болгож, олсон материалуудынхаа ч хэргийг гаргаж чаддаг юм. Урлаг намайг амьдруулдаг.”

Жэйкоб Браун Пенсильванийн Марс хотод өссөн бөгөөд гурван хүүхэдтэй айлын отгон хүү тэрбээр урлал, бүтээл туурвил түүний гэр бүлийнхний хамтдаа хийдэг зүйл байсныг үргэлж дурсдаг юм. Хэдийгээр тархины саажилт хөдөлгөөний чадварыг нь хязгаарладаг боловч нөгөө талаараа харааны хэл, бүтээлч байдлыг нь хөгжүүлэх түлхэц болж өгдөг байна.

Брауны уран бүтээл нь орон нутагтаа төдийгүй бүс нутаг, улсын хэмжээний үзэсгэлэнгүүдэд оролцож, хэд хэдэн шагнал авч байжээ. Түүний уран зураг нь абстракт бүтээлүүд бөгөөд тэрээр цэрд, бэх, акрил болон тосон будаг, толбо, лак, хаягдал металл зэрэг олон төрлийн материалыг хольж ашиглан уран бүтээлээ хийдэг. Брауны уран зургуудын өнгө, материалын чөлөөт сонголт нь тархины саажилтын улмаас хязгаарлагдсан хөдөлгөөний чадвараас нь эрс тэс ялгардаг.

Хөдөлгөөний хязгаарлагдмал байдал өөрийнх нь бүтээлч сэтгэлгээ, адал явдлыг эрэлхийлэгч чанарт нөлөөлөхийг тэрээр хэзээ ч зөвшөөрдөггүй. Тиймээс ч Ийгл Скаутын гишүүн төдийгүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан цанаар хичээллэж, бас “Гурван гол” сэлүүрт завины холбооны ХБИ-ийн багийн бүрэлдхүүнд багтан тэмцээн уралдаанд оролцдог. Тэрээр Пенсильванийн Питтсбург дахь Дикюеснигийн их сургуулийн Гэгээн Антони коллежийн түвшний хөтөлбөрт суралцдаг бөгөөд Best Buddies олон улсын байгууллагын Дикюесни дэх бүлгийн идэвхтэй гишүүн юм.





**Providence 3**, 2012. *Mixed media, 20 x 51 in. Courtesy of the artist, Mars, Pennsylvania*  
**Провиденс 3**, 2012. *Холимог техник, 50,8 x 129,5 см. Уран бүтээлчийн зөвшөөрөлтэй. Пенсильвани муж, Марс хот*

## SHANNON SZCZEKOT

“If someone finds beauty in the images I captured, then I believe they have seen one of my happiest moments.”

Shannon Szczekot was raised in a small town in North Florida and has lived throughout the South. As soon as she was old enough to travel on her own, she had a yearning to explore and travel the world. At the age of twenty-two, while participating in a Charity Challenge event through Disney World, in Orlando Florida, she met Pamela Mathues, a Disney animator, artist, and photographer, who introduced her to photography. She ventured West and made Aspen, Colorado, her home in 1999.

Having been a whitewater rafting guide on the Ocoee River in Tennessee, it was natural to combine photography with adventure trips. From the experience of an ‘All Artist’ Grand Canyon rafting trip organized by professional river guides and artists, she has continued to grow from photography workshops in Paige, Arizona; Kauai, Hawaii; and Aspen, Colorado. Szczekot has found much of her inspiration from photographers she has met and worked with while traveling.

In 2014, after returning from a photographic safari in Africa, Szczekot was reminded of the magic photography offers by allowing one to share their unique sights and experiences. While in Moshi, Tanzania, she had the opportunity to spend time and do some photography with kids at the Pamoja Tunaweza Boys and Girls Club. To see the joy in the eyes of these beautiful children, learning and participating, ignites a passion to share what she has learned along the way.

## ШЭННОН ЗЕШИКОТ

“Хэн нэгэн миний дарсан гэрэл зургаас гоо сайхныг олж харж байгаа бол миний хамгийн аз жаргалтай нэгэн мөчийг бас олж харжээ гэдэгт би итгэдэг.”

Шэннон Зешикот нь Флорида мужийн умард нутгийн нэгэн жижиг хотод өссөн боловч өмнөдөд голдуу амьдарсаар иржээ. Тэрээр бие даан аялах насанд хүрмэгцээ дэлхийгээр аялж, эрэл хайгуул хийх хүсэл тэмүүлэлтэй байв. 22 настайдаа тэрээр Флоридагийн Орlando дахь Дисней Уорлдoос зохион байгуулсан буяны арга хэмжээнд оролцох үеэрээ Диснейн хүүхэлдэйн кино бүтээгч, зураач, гэрэл зурагчин Памела Матеюстэй танилцаж улмаар гэрэл зургийн ертөнцөд татагдан орсон түүхтэй. Тэрээр баруун зүгт аялж явсаар 1999 онд Колорадогийн Аспенд суурьшсан байна.

Теннесси муж дахь Окои гол дээр рафт завины аяллын хөтөч байсны хувьд гэрэл зургуудаа адал явдалт аялалуудтайгаа холбох нь хэвийн зүйл байжээ. Мэргэжлийн хөтөч, уран бүтээлчдийн зохион байгуулсан “Бүгд уран бүтээлчид” хэмээх Гранд Канионы рафт завины аялалаар явсан туршлагаас эхлээд Аризонагийн Пэйж, Хавайн Кауай болон Колорадогийн Аспенд гэрэл зургийн студиудад ажиллангаа өсч хөгжсөөр байлаа. Зешикот нь уран бүтээлийн онгодынхоо ихэнхийг аялж явахдаа уулзсан, хамтарч ажилласан гэрэл зурагчдаас олж авдаг ажээ.

2014 онд Африкийн сафарид гэрэл зургийн аялал хийгээд буцаж ирснийхээ дараа Зешикот өөрт төрсөн онцгой сэтгэгдэл, үзсэн харснаа бусадтай хуваалцах гайхалтай боломжийг гэрэл зураг олгодог болохыг мэдэрчээ. Танзанийн Моши дахь “Паможа Тунавезагийн охид, хөвгүүдийн клуб”-т хүүхдүүдтэй цагийг хамтдаа өнгөрөөж, гэрэл зураг авах боломж түүнд олдсон байна. Хичээн суралцаж буй тэр хөөрхөн хүүхдүүдийн нүднээс гэрэлтэх баяр хөөрийг харахаар амьдралынхаа туршид сурсан зүйлсээ тэдэнтэй хуваалцах хүсэл эрмэлзлэлийг төрүүлдэг байна.



**Sunny and Sopris, September 23, 2013.** *Color photograph, 24 x 36 in. Courtesy of the artist, Carbondale, Colorado*

**Нарлаг өдөр, Соприс уул, 2013 оны 9-р сарын 23.** *Өнгөт гэрэл зураг, 61 x 91,4 см. Уран бүтээлчийн зөвшөөрөлтэй. Колорадо муж, Карбондэйл хот*

## KHASAANOVIIN ERDENE-OCHIR

“The overall themes of my work include Mongolian history, horses, and landscape. Thirteenth-century Mongol warriors and any theme relating to horses and the countryside (as I grew up in the countryside riding horses) have been the main source of my inspiration.”

Khasaanoviin Erdene-Ochir was born in Undur-Ulaan soum of Arkhangai province Mongolia. When he was just five years old, he recalls that one time he made a drawing and presented it to his mother and grandfather. His grandfather, very much taken by the drawing, commented that he would one day become an artist or a historian.

Erdene-Ochir’s deep interest in the arts began when he was in grade school. Various artists used to come and go from the province centers to paint and provide artwork for schools mainly for decorative purposes. During those times, he would stand and watch in admiration the visiting artists hard at work for hours. He recalls, it was then and there, that he decided to become an artist, and worked hard in developing and exploring his skills and creativity. After finishing grade school, he was accepted into the College of Fine Arts in Mongolia. He graduated in 1992, and has been working as an independent artist ever since.

Erdene-Ochir’s style combines realism and abstraction, and uses shades of bright and rich colors. He also likes to mix different media and techniques, such as oil and watercolor, creating interesting but unique textures and imagery. When working on a piece, he focuses more on the underlying story that he’s trying to portray, and through his brush strokes, strives to grasp his own emotions towards the painting.

Erdene-Ochir has participated in several collaborative exhibitions with local and international artists. Being a member of the Mongolian Union of Artists, in 2015, he held his first solo exhibition *Wallop*, and participated in the 6th Beijing International Art Biennale. In 2016, he again had conducted his solo exhibition *My steppe* in Hohhot Art Center, Inner Mongolia. He has received the national awards of Leading Cultural Artist (2011) and Honorable Achievement Award (2013).

## ХАСААНОВЫН ЭРДЭНЭ-ОЧИР

“Миний бүтээлүүдэд Монголын түүх, адуу мал, байгалийн сэдэв зонхилдог. 13-р зууны үеийн монгол дайчид болон адуу мал, (би хөдөө морь унаж өссөн болохоор) хөдөө орон нутагтай холбоотой сэдвүүд миний онгодыг хөглөдөг.”

Хасаановын Эрдэнэ-Очир Монгол Улсын Архангай аймгийн Өндөр-Улаан суманд төрсөн. Таван настай байхдаа тэрээр нэгэн зураг зурж, ээж, өвөө хоёртоо үзүүлж байснаа санадаг аж. Түүний өвөө зургийг нь үзээд сэтгэл нь ихэд хөдөлж, ирээдүйд зураач, эсвэл түүхч болох нь дээ хэмээн өгүүлжээ. Эрдэнэ-Очир дунд сургуулийн сурагч байхдаа уран зураг нилээд гүнзгий сонирхож эхэлсэн байна. Төвөөс зураач нар ихэнх тохиолдолд сургууль дээр нь будаг, чимэглэлийн ажил хийхээр ирдэг байв. Тэрээр зочилж ирсэн зураач нарыг ажиллаж байх үеэр олон цагийн турш бишрэн харж зогсдог байжээ. Яг тэр үед, тэнд л зураач болохоор шийдэж, ур чадвар, бүтээлч сэтгэлгээгээ олж нээн, хөгжүүлэхийн тулд маш их хөдөлмөрлөснөө тэрээр дурсан ярьдаг. Дунд сургуулиа төгсөөд Монголдоо Дүрслэх урлагийн дунд сургуульд элсэн орж, 1992 онд төгссөнөөсөө хойш чөлөөт уран бүтээлчээр өнөөг хүртэл ажиллаж байна.

Эрдэнэ-Очир уран бүтээлдээ реалист болон абстракт зургийн аргыг хослуулан хэрэглэдэг бөгөөд хурц тод ба гүн өнгөнүүдийн олон төрлийг ашигладаг. Тэрээр мөн тосон ба усан будаг зэрэг өөр өөр материал, арга техникүүдийг хольж, сонирхолтой мөртлөө өвөрмөц бичлэг, дүрслэлийг гарган зурах дуртай. Бүтээл дээр ажиллаж байхдаа зургаараа өгүүлэхийг зорьж буй түүхэд голчлон анхаарч, бийрийнхээ хөдөлгөөн бүрээр дамжуулан тухайн үеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлөө уран зурагтаа шингээхийг хичээдэг.

Эрдэнэ-Очир нь монгол болон олон улсын уран бүтээлчдийн хэд хэдэн хамтарсан үзэсгэлэнд оролцоод байна. Тэрээр Монголын урчуудын холбооны гишүүний хувьд 2015 онд анхны бие даасан “Төвөргөөн” үзэсгэлэнгээ гаргаж, Бээжингийн Олон улсын урлагийн 6-р биенналд оролцсон байна. 2016 онд тэрээр дахин бие даасан “Миний тал нутаг” үзэсгэлэнгээ Өвөр Монголын Хөх хотын Урлагийн төвд гаргасан байна. Тэрээр Соёлын тэргүүний ажилтан (2011) болон Хөдөлмөрийн хүндэт медалиар (2013) шагнуулсан байна.

**Wallop.** 2015  
*Oil on canvas, 55½ x 78¾ in.*  
*Courtesy of the artist, Ulaanbaatar, Mongolia*

**Төвөргөөн.** 2015  
*Зотон, тосон будаг, 140 x 200 см*  
*Уран бүтээлчийн зөвшөөрөлтэй.*  
*Монгол Улс, Улаанбаатар хот*



**Lake Khuvsgul.** 2015  
*Oil on canvas, 31½ x 47¼ in.*  
*Courtesy of the artist, Ulaanbaatar, Mongolia*

**Хөвсгөл Нуур.** 2015  
*Зотон, тосон будаг, 80 x 120 см*  
*Уран бүтээлчийн зөвшөөрөлтэй.*  
*Монгол Улс, Улаанбаатар хот*

## FRANCIE HESTER

## ФРЭНСИ ХЭСТЭР

“After more than two decades of painting, I have come to understand the ebb and flow of creating work in the quiet of a studio. Starting in 2001, I worked on a series titled *Strata*. This series grew out of a deafening silence that I felt after the Twin Towers went down. My world, our world, stopped. The studio went silent. I stripped my work of all imagery, and began to paint what I like to think of as chants – a spiritual beginning. One note, one color, one strip. If I painted anything that I thought was too precious or beautiful, I stripped it away. Was it missed? Was it there? This is the beginning from which the *Strata* series has evolved. Day by day, the monumental and the precious are wrapped together, forming a linkage, however fleeting. For this series, I worked on honey-combed aluminum panels. I built up the surface with dense layers of paint and then section-by-section sanded, drilled, and scraped it away, before rubbing the surface with a final layer of raw pigments and wax. The final surfaces feel and look like leather or the bark of a tree, in contrast to the distressed etched portions or the polished look of a patina left behind.”

Francie Hester was born in Columbus, Ohio, and holds a Bachelor of Fine Arts degree from the University of Michigan, and a Master of Fine Arts degree from the University of Maryland. For the past twenty years, she has been living and painting in Washington, D.C., and her work is represented internationally in numerous private and corporate collections, including the World Bank, the International Monetary Fund, Freddie Mac, Capital One, and KPMG International. Hester’s commissioned works include a 1996 piece for the Ginetta Sagan Fund of Amnesty International and an eighteen-foot atrium piece for the Chicago Kent College of Law. Her art has been shown in several group and solo exhibitions in Moscow, Russia; Monterey, California; and throughout the mid-Atlantic states of the United States.

[www.franciehester.com](http://www.franciehester.com)

Зураг зураад хорь гаруй жил өнгөрсний дараа л би нам гүмхэн студид уран бүтээлээ туурвих үйл явцын “татлага - түрлэг”-ийг ойлгож эхэлж байна. Би 2001 оноос эхлэн “Давхарга” нэртэй цуврал дээр ажилласан. Энэхүү цуврал Ихэр цамхаг нуран унасны дараа миний мэдэрч байсан тэр хачин дүнсгэр, “дүлийрэм” нам гүмээс үүссэн юм. Миний ертөнц, бидний ертөнц бүхэлдээ зогсож, студи маань хүртэл нам гүм болсон байлаа. Би төсөөлөн бодсон бүтээлээ зурвас хэсгүүдэд хуваан, сүсэг бишрэлийн эхлэл буюу маанийн үсгүүдийг хэлхэж буй мэт нэг нэгээр нь зурж эхэлсэн юм. Нэг ноот, нэг өнгө, нэг судал. Хэтэрхий эрхэм нандин, эсвэл гоё сайхан гэж бодсон зүйлээ зурж байхдаа би түүнийгээ нарийн судлууд болгон хувааж үзсэн. Тэр эрхэм нандин зүйл нь алдагдсан уу? Эсвэл хэвээрээ байна уу? Энэ бол “Давхарга” цуврал үүсч бий болохын эхлэл байлаа. Өдөр ирэх тусам сүр жавхлан болоод эрхэм нандин хоёр нэгдэн нийлж, агшин зуурын боловч хэлхээ холбоос үүсгэж байлаа. Энэ цуврал дээр ажиллахдаа би зөгийн үүрэн хэлбэртэй хөнгөн цагаан хавтангууд ашигласан. Би гадаргууг нь нягтрал сайтай будгаар давхарлан будаж бэхжүүлснийхээ дараа хэсэг хэсгээр нь зүлгүүрдэж, дриллэн өнгөлгөө хийж, хусаж цэвэрлээд эцэст нь байгалийн шороон будаг болон вакс түрхэж бэлдсэн. Ингэж бэлдсэн гадаргуу яг л савхи, эсвэл модны холтос шиг харагдаж, мэдрэгдэхээс гадна зарим хэсгээрээ хуучирч хонхойсон, эсвэл мөлийж элэгдсэн мэт байдалтай болдог.”

Фрэнси Хэстэр нь Охайо мужийн Коламбус хотод төрсөн бөгөөд Мичиганы их сургуулийн Дүрслэх урлагийн бакалавр болон Мэрилэндийн их сургуулийн Дүрслэх урлагийн магистр цолтой. Сүүлийн хорин жилийн туршид тэрээр Вашингтон хотод амьдарч, уран бүтээлээ туурвиж байгаа бөгөөд түүний бүтээлүүдийг Дэлхийн банк, Олон улсын валютын сан, Фредди Мак, Капитал 1, КПМЖ Интернэшнл зэрэг олон байгууллагууд хувийн болон байгууллагын цуглуулгадаа хадгалж байдаг. Хэстэрийн бүтээлүүд дотор Эмнести Интернэшнлийн “Жинетта Саган” сангийн захиалгаар 1996 онд хийсэн ажил болон Чикагогийн Кент хуулийн коллежийн асарт танхимд зориулан бүтээсэн арван найман футын өндөртэй ханын чимэглэл зүй ёсоор багтдаг. Түүний уран бүтээлийг ОХУ-ын Москва, Калифорнийн Монтерэй болон АНУ-ын зүүн эргийн мужуудад зохион байгуулагдсан хэд хэдэн хамтарсан болон бие даасан үзэсгэлэнгүүдэд дэлгэн үзүүлсэн байна.

[www.franciehester.com](http://www.franciehester.com)



*Left:*

**Timepiece O**, 2010

*Mixed media, 36 x 12 x 6 in.*

*Courtesy of the artist, Kensington, Maryland*

**Цаг хугацаа О**, 2010

*Холимог материал, 91,4 x 30,5 x 15,2 см*

*Уран бүтээлчийн зөвшөөрөлтэй.*

*Мэрилэнд муж, Кенсингтон хот*



*Right:*

**Timepiece N**, 2010

*Mixed media, 36 x 12 x 6 in.*

*Courtesy of the artist, Kensington, Maryland*

**Цаг хугацаа Н**, 2010

*Холимог материал, 91,4 x 30,5 x 15,2 см*

*Уран бүтээлчийн зөвшөөрөлтэй.*

*Мэрилэнд муж, Кенсингтон хот*

## PEGGY JUDY

Peggy Judy was born to be an artist. She realized that even as a child. Her destiny was sealed by one important fact: she was smitten by the natural beauty of her native Colorado. So, she painted and drew throughout her high school and college years. Upon graduation from Colorado State University in 1982 with a Bachelor of Fine Arts degree with a concentration in illustration, she began her professional career as an illustrator, working for various corporations and the Department of Energy, all in the Denver, Colorado, area.

When she married an equine veterinarian in 1988, Judy was able to meld her passion for all things “horse” with her art, although she spent much of her time breeding, raising, training, and selling Warmblood Sport horses. Today, having raised her two children (both are accomplished horsemen), she has more time and a renewed vigor for painting.

In 2013, Peggy Judy won First Place or Best in Show at the Tesoro Spanish Culture and Western Art Show in Morrison, and the Fine Arts Festival in Golden, both in Colorado. In 2014, she was included in two museum exhibitions: the Mattatuck Museum in Connecticut and the Rockwell Museum of Western Art in New York.

[www.korologogallery.com](http://www.korologogallery.com)

## ПЭГГИ ЖЮДИ

Пэгги Жюди бол төрмөл уран бүтээлч хүн. Тэрээр хүүхэд байхаасаа л үүнийг ойлгосон байна. Түүний хувь заяа нэгэн чухал тохиолоор шийдэгдсэн нь юу вэ гэвэл тэрээр төрөлх Колорадо мужийнхаа байгалийн гоо үзэсгэлэнг гайхан биширч өсчээ. Тиймээс ахлах сургууль, коллежээ төгсөн төгстлөө зурсаар л байв. 1982 онд Колорадо мужийн их сургуулийг зураач-чимэглэгч мэргэжлээр дүрслэх урлагийн бакалавр зэрэгтэй төгссөнийхөө дараа Колорадо мужийн Денвер хот болон түүний ойр орчимд янз бүрийн байгууллага, компаниуд, түүний дотор Эрчим хүчний яаманд зураач-чимэглэгчээр ажиллаж, ажлын гараагаа эхэлсэн байна.

Жюди 1988 онд адуугаар мэргэшсэн малын эмчтэй гэрлэснийхээ дараа Warmblood үүлдрийн спорт адууг үржүүлэх, өсгөх, сургах, худалдан борлуулах ажилд ихэнх цагаа зориулж байсан хэдий ч “адуу”-тай холбоотой бүхий л зүйлд дурласан сэтгэлээ уран бүтээлтэйгээ зохицуулан нийцүүлж чадсан юм. Өнөөдөр хоёр хүүхэд нь өсч том болсон болохоор (аль аль нь сайн адуучин болжээ) зургаа зурах цаг ч нэмэгдэж, шинэ эрч хүчийг олжээ.

Пэгги Жюди 2013 онд Колорадо мужийн Моррисон хотод болсон “Испани соёл ба Вэстэрн урлагийн Тесоро наадам”, мөн Голденд болсон “Дүрслэх урлагийн наадам”-аас эхний байрт шалгарч байжээ. 2014 онд Коннектикутын Маттатук музей болон Нью-Йорк дахь Вэстэрн урлагийн Роквелл музейн үзэсгэлэнгүүдэд түүний бүтээлүүд тавигдсан байна.

[www.korologogallery.com](http://www.korologogallery.com)





**The Girls**, 2013. *Acrylic on canvas, 24 x 36 in. Courtesy of the artist and Korologos Gallery, Basalt, Colorado*  
Охид, 2013. *Зотон, акрил, 61 x 91,4 см. Уран бүтээлч болон Корологос галерейн зөвшөөрөлтэй. Колорадо муж, Базалт хот.*

## TOM KOROLOGOS

Tom Korologos's photography is a product of his extensive travel and his love of art. He has taken numerous photographic courses, including one from National Geographic and several at Anderson Ranch in Snowmass, Colorado. His works grace many important collections, including those of foreign diplomats and elected officials. Korologos continues to shoot interesting people and places wherever he goes. His favorite quote is, "Photography keeps you in focus."

He served as United States Ambassador to the Kingdom of Belgium from July 2004 through February 2007. From May to December, 2003, Ambassador Korologos was Senior Counselor to Ambassador L. Paul Bremer, Administrator, Office of Coalition Provisional Authority (CPA) in Baghdad, and in the Defense Department, Washington, D.C.

Prior to going to Baghdad, from 1975 to 2003, Korologos served as Chairman of the Executive Committee and was co-founder of Timmons and Company, a Washington consulting firm. He served in the Nixon and Ford Administrations as Deputy Assistant to the President for Legislative Affairs (Senate). He also served nine years under Senator Wallace F. Bennett.

In 1980-1981, Korologos served as Director of Congressional Relations for President Ronald Reagan's transition and served both the Reagan and Bush Administrations as a volunteer assisting in various Senate confirmations. He also was Director of Congressional Relations for the National Bipartisan (Kissinger) Commission on Central America.

Korologos has traveled extensively overseas as a member and Chairman of the Advisory Commission on Public Diplomacy, and from 1995 to 2002 as a member of the Broadcasting Board of Governors, which has jurisdiction over all non-military US Government radio and TV broadcasting overseas. Earlier in his career, Korologos was a journalist with the *New York Herald Tribune*, the *Long Island Press*, the *Salt Lake Tribune* and the Associated Press.

Korologos earned his Bachelor of Arts degree at the University of Utah (Salt Lake City) and his Master of Science degree at Columbia University Graduate School of Journalism (New York), where he received the Grantland Rice Fellowship and a Pulitzer Fellowship. He was born in 1933 in Salt Lake City, Utah, and is married to Ann McLaughlin Korologos, former Secretary of Labor.

[www.korologosgallery.com](http://www.korologosgallery.com)

## TOM КОРОЛОГОС

Том Корологосын гэрэл зураг бол түүний хийсэн олон аялалууд болон урлагт өгсөн хайраас нь төрсөн бүтээгдэхүүн юм. Тэрээр Колорадо мужийн Сноумасс дахь Андерсон Ранч урлагийн төв болон National Geographic-аас зохион байгуулдаг гэрэл зургийн хэд хэдэн курс, сургалтанд суусан байна. Түүний уран бүтээл нь гадаадын дипломатууд болон албан тушаалтнуудын гэрэл зургууд бүхий сонирхолтой олон цуглуулгаас бүрддэг. Корологос хаа явсан газартаа сонирхолтой газар нутаг, хүмүүсийг хальсандаа буулгасаар иржээ. "Гэрэл зураг таныг фокуст байлгадаг" гэж тэр хэлэх дуртай.

Тэрээр 2004 оны 7-р сараас 2007 оны 2-р сар хүртэл Бельгийн Вант Улсад суух АНУ-ын Элчин сайдын албан тушаалыг хашиж байжээ. 2003 оны 5-р сараас 12-р сар хүртэл тэрбээр Багдад дахь Эвслийн түр эрх барих газар (ЭТЭБГ)-т Тамгын газрын даргаар ажиллаж байсан Элчин сайд Д. Пол Брэмэрийн ахлах зөвлөхөөр, мөн Вашингтонд Батлан хамгаалах яаманд ажиллаж байжээ.

Багдадаас өмнө 1975-2003 он хүртэл Корологос нь Вашингтоны зөвлөх компани болох "Тиммонс ба Компани"-ийг хамтран үүсгэн байгуулж, гүйцэтгэх хорооны даргаар нь ажиллаж байжээ. Тэрээр Никсон болон Фордын засаг захиргаанд Ерөнхийлөгчийн хууль зүйн асуудал (Сенат) эрхэлсэн шадар туслахаар ажиллаж байсан. Мөн Сенатор Уоллас Ф. Бэннэтийн удирдлага дор 9 жил ажиллажээ.

Корологос 1980-1981 онуудад Ерөнхийлөгч Рональд Рейганы шилжилтийн засаг захиргаанд Конгрессийн харилцаа хариуцсан захирлаар, Рейган болон Бушийн засаг захиргааны аль алинд нь Сенатаар албан томилгоо хэлэлцүүлж, батлуулахад сайн дурын ажилтнаар ажиллажээ. Тэрээр мөн Төв Америкийн асуудлаарх Хоёр намын үндэсний (Киссинжер) комиссын Конгрессийн харилцаа хариуцсан захирлаар ажиллаж байсан юм.

Корологос нь Олон нийтийн дипломат ажилагааны Зөвлөх комиссын гишүүн, даргын хувиар, мөн 1995-2002 онуудад хилийн чанадад АНУ-ын Засгийн газрын цэргийн бус зориулалттай радио, телевизийн бүх нэвтрүүлгийг хянан зохицуулдаг Өргөн нэвтрүүлгийн захирагчийн зөвлөлийн гишүүний хувиар гадаад улс орнуудад маш их аялжээ. Тэрээр Нью-Йорк Хералд Трибун, Лонг Айланд Пресс, Солт Лэйк Трибун болон Ассошиэтэд Пресс зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудад сэтгүүлчээр ажиллаж, ажлын гараагаа эхэлсэн байдаг.

Корологос нь Солт Лэйк хот дахь Ютагийн их сургуулиас бакалавр зэрэг хүртсэн бол Нью-Йорк хотын Коламбиа их сургуулийн Сэтгүүл зүйн сургуульд Грантлэнд Райс болон Пулитцериин тэтгэлгээр суралцаж, шинжлэх ухааны магистр цолтой төгсжээ. Тэрээр Юта мужийн Солт Лэйк хотод 1933 онд төрсөн бөгөөд эхнэр нь Хөдөлмөрийн сайд асан Энн МакЛафлин Корологос юм.

[www.korologosgallery.com](http://www.korologosgallery.com)



**Splitting the Rays, Snowmass 03, 2011.**

*Photograph on archival paper, 15 x 20 in.*

*Courtesy of the artist and Ann Korologo Gallery, Basalt, Colorado*

**Сноумасс дахь нарны гэрлийн тусгал, 2011 оны 3-р сар**

*Архивийн баримт дахь гэрэл зураг, 38,1 x 50,8 см*

*Уран бүтээлч болон Энн Корологос галерейн зөвшөөрөлтэй.*

*Колорадо муж, Базалт хот*



**Winter Feeding 03, 2010**

*Photograph on archival paper, 14 x 21 in.*

*Courtesy of the artist and Ann Korologos Gallery, Basalt, Colorado*

**Өвлийн бэлчээрт, 2010 оны 3 дугаар сар**

*Архивийн баримт дахь гэрэл зураг, 35,6 x 53,3 см*

*Уран бүтээлч болон Энн Корологос галерейн зөвшөөрөлтэй.*

*Колорадо муж, Базалт хот*

## CAROL ANN WAUGH

Carol Ann Waugh's fiber art has been juried and invited into more than fifty national and international exhibitions. Numerous publications have featured her works and she has authored several books, most recently, *Stupendous Stitching*.

Waugh was commissioned to create a piece for the Eastside Human Services Building for the City of Denver, Colorado. Her work is in many private and public collections, including the Denver International Airport (DIA). In addition, Waugh teaches her courses online at [Craftsy.com](http://Craftsy.com) where more than 35,000 students from more than 150 countries worldwide are learning her techniques.

Waugh also teaches a six-month long artist mentorship class for emerging artists on how to present and sell artwork to Denver buyers. In 2013, she opened a Contemporary Art Gallery (aBuzz Gallery) in the RiNo Art District of Denver.

[www.CarolAnnWaugh.com](http://www.CarolAnnWaugh.com)

## КЭРОЛ ЭНН ВАХ

Кэрол Энн Вахын даавуун урлалын бүтээлүүд үндэсний төдийгүй олон улсын 50 гаруй үзэсгэлэнд шалгаран уригдаж байжээ. Түүний уран бүтээлүүд маш олон ном, сэтгүүлүүдэд нийтлэгдсэн бөгөөд тэр өөрөө ч хэд хэдэн ном бичсэний хамгийн сүүлчийнх нь "Гайхалтай хатгамал" ном юм.

Вах нь Колорадо мужийн Денвер хотын Ийстсайд Хүмүүнлэгийн үйлчилгээний барилгад захиалгаар бүтээл хийхээр сонгогдож байжээ. Түүний уран бүтээлүүд томоохон хувийн болон олон нийтийн цуглуулганд, түүний дотор Денверийн олон улсын нисэх буудал дээр байдаг. Түүнээс гадна Вах [Craftsy.com](http://Craftsy.com) дээр онлайнаар хичээлээ заадаг бөгөөд дэлхийн 150 гаруй орны 35,000 гаруй хүн түүний арга техникээс суралцдаг байна.

Мөн Денверчүүдэд уран бүтээлээ хэрхэн танилцуулж, худалдах талаар шинэ залуу уран бүтээлчдэд зориулсан зургаан сарын менторын хөтөлбөр явуулж, хичээл заадаг ажээ. 2013 онд тэрээр Денверийн РиНо (RiNo) урлагийн дүүрэгт Контемпорари урлагийн галерей (aBuzz галерей) нээсэн байна.

[www.CarolAnnWaugh.com](http://www.CarolAnnWaugh.com)

**Undulations**, 2009  
*Hand dyed fabric*  
*(made by another artist)*  
48 x 48 in.  
*Courtesy of the artist, Denver, Colorado*

**Долгионууд**, 2009  
*Гараар будсан даавуу*  
*(өөр уран бүтээлч хийсэн)*  
121,9 x 121,9 см  
*Уран бүтээлчийн зөвшөөрөлтэй.*  
*Колорадо муж, Денвер хот*



# CHARLOTTE ZIEBARTH

# ШАРЛОТТ ЗИЕБАРТ

“For the last 15 years my textile work has been a hybrid of photography, digital art, and quilt art. The inspiration for most of my work comes from the patterns seen in close-up details of my photographs. Exploring the digital alteration possibilities of these ‘found art’ lines and shapes is what I like to do. I am seeking new ways to use these digital compositions to print on silk and collage into a quilt. More and more it is the abstract qualities rather than the representational that interest me. For several years now I have focused on water imagery.

My techniques involve three major activities:

1) Taking Photographs: I start with realistic or abstract images that I have captured with my camera—single moments in time that focus the attention on the details of what I am observing.

2) Making Digital Art: I aim to highlight abstract patterns unnoticed at the initial observation. My resulting images are an exploration of these patterns, both natural and manmade. The result is an abstract impression which has a sense of the reality from which it is derived.

3) Creating a Quilt: Printing my digital paintings on cloth allows me to take advantage of the textures and light reflecting variations of different kinds of fabrics. Stitching is an important part of my process. It is fascinating and mesmerizing as a process and allows me to participate in the traditions of the quilter’s world.”

Charlotte Ziebarth quilts have appeared in many publications and national juried exhibitions. She earned the Persistence Pays award in the 2013 Quilt National.

Although Ziebarth has an academic background in psychology, she has worked with art and cloth most of her life as a professional dyer, tapestry weaver, clothing designer, knitter, and quilter. After many years working principally as a weaver she fell in love with digital art possibilities and presently concentrates on creating digital imagery printed on fabric and assembled into quilt art.

When not working in the digital darkroom or her sunny quilting and painting studio, she can be found knitting, listening to opera, or hiking in the mountains with her camera. She was born in Chicago and raised in the Midwest. She has lived with her husband, Ken, in Boulder, Colorado, for more than thirty-five years.

[www.charlotteziebarth.com](http://www.charlotteziebarth.com)

“Сүүлийн 15 жилийн турш даавуун урлалын бүтээлүүд маань гэрэл зураг, дижитал урлаг болон зүймэл даавуун урлалын хослол байсаар ирсэн. Би уран бүтээлийнхээ ихэнх санааг гэрэл зурагт маань буусан хэлбэр дүрс, деталиудыг тодруулан харж байгаад олдог. Эдгээр “олдмол урлаг”-ийн шугам, хэлбэр дүрсүүдийг дижитал болгон хувиргах боломжийг олж нээх нь миний хийх дуртай ажил юм. Би эдгээр дижитал зохиомжийг торгон дээр буулгаж, зүймэл болгон эвлүүлэх шинэ арга замыг хайж байна. Бодит гэхээсээ илүүтэйгээр абстракт шинж чанар нь миний сонирхлыг ихээр татдаг. Нэлээд хэдэн жилийн туршид би усны зураглалд ихээхэн анхаарал хандуулсаар ирлээ.

Миний хэрэглэдэг арга техник 3 үндсэн хэсгээс бүрддэг. Үүнд:

1) Гэрэл зураг авах. Ажиглаж байгаа зүйлийнхээ аль нэг детальд хамаг анхаарлаа хандуулах тэр цорын ганц хормыг буулгасан бодит эсвэл абстракт гэрэл зургаас би ажлаа эхэлдэг.


2) Дижитал загвар хийх. Анх харахад анзаарагдаагүй абстракт дүрсүүдийг онцлон харахыг хичээдэг. Байгалийн төдийгүй хүний гараар бүтсэн эдгээр хээ угалз, хэлбэр дүрсүүдийг олж нээсний үр дүнд анхнаасаа түүнийг бий болгосон бодит байдлын мэдрэмжийг өөртөө агуулсан абстракт дүрслэлийг би гаргаж ирдэг юм.

3) Хөдрөг буюу зүймэл даавуун урлал хийх. Дижитал зургуудаа даавуун дээр буулгах нь олон төрлийн бөс материалын бүтэц болоод гэрэл ойлгох чадварыг нь харгалзан ашиглах боломжийг надад олгодог юм. Оёдол бол энэ ажлын нэг чухал хэсэг юм. Энэ бүх үйл явц гайхалтай, сэтгэл татам бөгөөд зүймэлчний ертөнцийн уламжлалт арга ажиллагаа бүрт намайг өөрийн эрхгүй татан оруулдаг юм.”

Шарлотт Зиебартын зүймэлүүд олон хэвлэлд нийтлэгдэж, үндэсний үзэсгэлэнгүүдэд шалгарсаар байгаа юм. Тэрээр 2013 оны Үндэсний зүймэл даавуун урлалын “Зүтгэлийн үр” шагналын эзэн болжээ.

Зиебарт хэдийгээр сэтгэл судлалын боловсролтой ч мэргэжлийн будагчин, аравч сүлжигч, хувцасны загвар зохион бүтээгч, нэхмэлчин, зүймэлчнээр ажиллаж, урлаг болоод даавуун урлалд ихэнх цагаа зориулжээ. Нэхмэл, сүлжмэлээр олон жил дагнан ажилласныхаа дараа тэрээр дижитал урлагийн хязгааргүй боломжид шимтэн дурлах болжээ. Одоо тэрбээр даавуун дээр дижиталаар зураг буулгаж, түүнийгээ зүймэл урлал болгох чиглэлээр голчлон ажиллаж байна. Тэрээр дижитал орчин бүхий харанхуй өрөөндөө ажиллаж, эсвэл нар гийсэн студидээ зүймэл хийж, зураг зураагүй байх үедээ юм нэхэж, опера сонсож, эсвэл гэрэл зургийн аппаратаа аваад зуланд аялдаг. Зиебарт Чикагод төрсөн бөгөөд Америкийн баруун төвийн нутагт өссөн юм. Тэрээр нөхөр Кений хамт 35 гаруй жил Колорадогийн Баулдерт амьдарч байна.

[www.charlotteziebarth.com](http://www.charlotteziebarth.com)



**Urban Reflections #2**, 2010. *Quilt, 31 x 44 in. Courtesy of the artist, Boulder, Colorado*  
**Хотын тусгалууд #2**, 2010. *Зүймэл даавуу, 78,7 x 111,8 см. Уран бүтээлчийн зөвшөөрөлтэй. Колорадо муж, Баулдэр хот*

## ACKNOWLEDGMENTS / ТАЛАРХАЛ

### Washington, D.C. / Вашингтон Ди Си

*Sarah Tanguy, Curator / Сара Тангай, Музейн эрхлэгч*

*Danielle Fisk, Registrar / Дэниел Фиск, Бүртгэгч*

*Sally Mansfield, Editor / Салли Мансфилд, Редактор*

*Amanda Brooks, Imaging Manager / Аманда Брүүкс, Зураглалын менежер*

*Victoria See, Assistant Editor / Виктория Сий, Туслах редактор*

*Tabitha Brackens, Publications Project Coordinator / Табита Брэкэнс, Хэвлэлийн төслийн зохицуулагч*

### U.S. Embassy Ulaanbaatar / Улаанбаатар дахь АНУ-ын Элчин сайдын яам

*Evan Roberson, Facility Manager / Эван Робертсон, Барилгын хэлтсийн менежер*

*Muyagmarsuren Jamiyasuren, Painter/Carpenter / Жамьяансүрэнгийн Мягмарсүрэн, мужаан*

*Enkhbat Zagdsuren, FMS Assistant / Загдсүрэнгийн Энхбат, өрлөгчин*

*Ganbat Dondov, FMS Assistant / Дондовын Ганбат, туслах ажилтан*

*McKenzie (Milanowski) Louw, Public Affairs Officer / МакКензи (Милановски) Лоу, Олон нийттэй харилцах албаны дарга*

*Erdenetssetseg Bat-Erdene, Cultural Program Assistant / Бат-Эрдэнийн Эрдэнэцэцэг, соёлын хөтөлбөр хариуцсан ажилтан*

*Tuul Chogsomjav, Translator / Чогсомжавын Туул, орчуулагч*

*Crown Relocation crew / Crown Relocation компанийн хамт олон*

### Union of Mongolian Artists / Монголын урчуудын эвлэл

*B. Tumurbaatar, Director / Б. Төмөрбаатар, захирал*

*Ts. Solongo, Director of Foreign Relations Department / Ц. Солонго, Гадаад харилцааны хэлтсийн дарга*

### Vienna / Вена

*Nathalie Mayer, Graphic Designer / Натали Мэйер, График дизайнер*



<http://art.state.gov>